



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/275

Чойр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Аймгийн 2022 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 оны аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар “Төрийн байгууллагуудыг цахимжуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, сурагчийн ширээ, сандал худалдан авах” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Болд-Эрдэнэ

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Ө.Мөнхгэрэл

(Аймгийн Засаг даргын туслах)

Г.Чинмэргэн

(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн)

Хөндлөнгийн төлөөлөл:

Ө.Наранчулуун

(Сүмбэр сумын 3 дугаар багийн иргэн)

Нарийн бичгийн дарга:

Г.Хонгор

